МОНГОЛЫН НОТАРИАТЧДЫН ТАНХИМ



# ЦАХИМ НОТАРИАТЫН СИСТЕМИЙН ГАРЫН АВЛАГА

**Улаанбаатар хот**

**2022 он**

# Агуулга

**1. СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА** ........ 2

1 Оршил ........ 2

Системд ашиглагдах нэр томьёоны тайлбар: ........ 2

**2. СИСТЕМ АШИГЛАХ ЗААВАР** ........ 2

1 Системд нэвтрэх ........ 3

**Системд хэрхэн нэвтрэх вэ?** ........ 3

**Системд хэрхэн бүртгүүлэх вэ?** ........ 3

**Нууц үг хэрхэн сэргээх вэ?** ........ 4

2 Сайтын бүтэц ........ 5

Үйлчилгээ цонхтой ажиллах ........ 6

Миний үйлчилгээ цонхтой ажиллах ........ 7

## 1. СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү систем нь үйлчлүүлэгчийг үнэн зөв танихаас эхлэн, үйлдэл бүртгэх, баталгаажуулах, архивлах тоо мэдээлэл гаргах, холбогдох баримт бичгийг төрийн байгууллагууд руу илгээх, мэдээлэл солилцон ажилладаг.

### 1 ОРШИЛ

Нотариатын тухай хууль: 41 дүгээр зүйлд Итгэмжлэл үйлдэх тухай

41.1.Итгэмжлэлд төлөөлүүлэгч болон төлөөлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, итгэмжлэл олгосон он, сар, өдөр, төлөөлүүлэгчээс төлөөлөгчид олгож байгаа бүрэн эрх болон хугацааг бичнэ.

41.2.Төлөөлөгчид эрх олгосон үйл ажиллагааг бусдаар гүйцэтгүүлэх, эсхүл итгэмжлэлийг бусдад шилжүүлэх бол энэ тухай итгэмжлэлд тусгайлан заах бөгөөд ийнхүү заагаагүй бол төлөөлүүлэгчийн ашиг сонирхлыг хамгаалах зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд шилжүүлсэн итгэмжлэлийг гэрчлэхийг хориглоно.

Итгэмжлэл үйлдэхдээ анхаарах зүйлс:

1. Итгэмжлэлд төлөөлөгч болон төлөөлүүлэгч талууд цахим иргэний үнэмлэх, гадаад паспортны хуулбар хавсаргана.
2. Ямар эрх олгох гэж байгаагаасаа хамааран нэмэлт бичиг баримт хавсаргана. Жишээ нь: Үл хөдлөх хөрөнгө бусдад худалдах, хөлслүүлэх, түрээслүүлэх, барьцаанд тавих, арилжих эрх олгох бол уг хөрөнгийн гэрчилгээний хуулбарыг хавсаргана.
3. Ямар эрх олгох гэж байгаагаа тодорхой сонгох.
4. Төлөөлөгч тал нь төлөөлүүлэгч талын өмнөөс өөртэйгөө хэлцэл хийхийг хуулиар хориглодог тул үүнийг анхаарах шаардлагатай.

### Системд ашиглагдах нэр томьёоны тайлбар:

| | Товчилсон үг | Тайлбар |
|---|---|---|
| 1. | ДТГ | Дипломат төлөөлөгчийн газар |
| 2. | Төлөөлүүлэгч | Итгэмжлэлээр олгох эрхийг төлөөлөгч талд олгох иргэн |
| 3. | Төлөөлөгч | Итгэмжлэлээр олгох эрхийн дагуу төлөөлүүлэгч талыг орлох иргэн |

## 2. СИСТЕМ АШИГЛАХ ЗААВАР

Интернэт хөтчийн хайлтын хэсэгт https://e.notary.mn/consul/mn бичиж хайлт хийж нэвтэрч орно.

## 1 СИСТЕМД НЭВТРЭХ

### Системд хэрхэн нэвтрэх вэ?




*Зураг 1. Нүүр хуудас*

- **Нүүр хуудас**ны нэвтрэх хэсэгт **Хэрэглэгчийн нэр, Нууц үг**ийг бичиж нэвтрэх товчийг дарж системд нэвтэрнэ.

### Системд хэрхэн бүртгүүлэх вэ?

Хэрэглэгч шинээр системд бүртгүүлж хэрэглэгчийн эрх үүсгэхдээ Э-мэйл хаяг ашиглана.

- **Нүүр хуудас**ны **Шинээр бүртгэл үүсгэх үү?** товч дарж бүртгэл хийх хуудсанд шилжинэ.




*Зураг 2. Хэрэглэгч системд бүртгүүлэх хуудас*

- **Бүртгүүлэх хуудас**ны хэрэглэгчийн хувийн мэдээлэл бөглөх талбаруудыг бөглөж **Бүртгүүлэх** товч дарна.
    - **Регистрийн дугаар**-Бүртгүүлж буй хэрэглэгчийн регистрийн дугаарыг оруулна.
    - **Овог**- Эцэг эхийн нэрийн мэдээллийг оруулна.
    - **Нэр** –Өөрийн нэрийн мэдээллийг оруулна.
    - **Цахим шуудан**- Хэрэглэгч ашигладаг э-мэйл хаягийн мэдээллийг оруулна.
- Хэрэглэгчийн бүртгүүлсэн Э-мэйл хаягт нэвтрэх нэр, нууц үгийг агуулсан цахим шуудан илгээгдэнэ.

## Нууц үг хэрхэн сэргээх вэ?

Хэрэглэгч системд нэвтрэх нууц үгийг мартсан тохиолдолд системд бүртгэл үүсгэсэн э-мэйл хаягаар дамжуулан сэргээх боломжтой.




*Зураг 3. Нууц үг сэргээх*

- **Нүүр хуудас**ны Нууц үгээ мартсан уу? товч дарж нууц үг сэргээх хуудсанд шилжинэ.
- **Цахим шуудан** талбарт системд бүртгүүлсэн э-мэйл хаягийг бөглөж **Илгээх** товч дарна
- Хэрэглэгчийн э-мэйл хаягт системд нэвтрэх нууц үгийг агуулсан шуудан илгээгдэнэ.

## 2 САЙТЫН БҮТЭЦ




### Нүүр хуудас

Системийн **Нүүр хуудас** цэсэн дээр дархад Монголын Нотариатчдын холбооны танилцуулгын сайтанд шилжнэ.




*Зураг 5.Нүүр хуудас*




*Зураг 6.Нотариатын танхим танилцуулгын веб хуудас.*

## Үйлчилгээ цонхтой ажиллах

Үйлчилгээ цонхны итгэмжлэлийн төрлөөс сонгож итгэмжлэлээ үйлдэнэ. Итгэмжлэл сонгохдоо төлөөлөгчид ямар эрх олгохоос шалтгаалж сонгоно.




*Зураг 7. Үйлчилгээ авах цонх*

## Миний үйлчилгээ цонхтой ажиллах

Миний үйлчилгээ цонхонд хэрэглэгчийн үйлдсэн итгэмжлэлийн жагсаалт харагдана. Энэ цонхонд итгэмжлэл хянуулах, итгэмжлэлийн агуулга засах, итгэмжлэлийн жагсаалтаас хайлт хийх, үйлдсэн итгэмжлэл харах боломжтой.




*Зураг 8. Миний үйлчилгээ цонх*

## *Миний үйлчилгээ жагсаалтаас хайлт хийх*




*Зураг 9.Миний үйлчилгээ жагсаалтаас хайлт хийх*

- 

Үйлчилгээний жагсаалтаас хүсэлтийн дугаараар хайлт хийх боломжтой.
- 

Үйлчилгээний жагсаалтаас үйлчилгээний нэрээр хайлт хийх боломжтой.
- 

Үйлчилгээний жагсаалтаас үйлчилгээний төлөвөөр шүүлт хийх боломжтой
- 

Дээрх талбаруудад утга оруулаад хайх товч дарж шүүлт хийнэ.
- 

Дээрх талбаруудад оруулсан утгуудыг цэвэрлэнэ.

## *Үйлдэл хянуулах*

Үйлдсэн итгэмжлэлийг хянуулах төлөвт оруулж ДТГ-ын ажилтанд илгээнэ. ДТГ-ын ажилтан шаардлага хангасан итгэмжлэлийн хүсэлтийг **Зөвшөөрсөн** төлөвт оруулна. Шаардлага хангаагүй гэж үзвэл **Буцаасан** төлөвт оруулна.




*Зураг 10.Итгэмжлэл хянуулах*

1. Миний үйлчилгээ цонхыг нээж үйлдлийн жагсаалтаас хянуулах үйлчилгээгээ сонгоно.
2. Сонгосон үйлчилгээний ард байрлах Хянуулах товч дээр дарна.
3. Санамжтай танилцаад **Тийм** дарж хянуулах төлөвт оруулна.




*Зураг 11.Санамж анхааруулга*




*Зураг 12. Хянуулах төлөвт орсон үйлдлийн жагсаалт.*

## *Үйлдэл харах*




*Зураг 13.Үйлдсэн итгэмжлэлийн агуулга харах.*

Үйлдсэн итгэмжлэлийн агуулгыг миний итгэмжлэл цонхноос харах боломжтой. Үйлчилгээний жагсаалтаас агуулга харах итгэмжлэл сонгож жагсаалтын арын Харах товч дээр дарна.



Еренхий итгэмжлэл

АРАБЫН НЭГДСЭН ЭМИРАТ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙДЫН ЯАМ НОТАРИАТЧИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

**ИТГЭМЖЛЭЛ**

Бүртгэлийн дугаар #bookNumber#

2022 оны 07 сарын 24 өдөр 16 цаг 55 минут Абу Даби

Монгол улсын Иргэний хуулийн **62, 64** дүгээр зүйлд заасныг үндэслэн:
**Төлөөлүүлэгч:**Улаанбаатар, Баянгол, 2-р, Андууд 49-р байр хаягт оршин суух ак12345678 регистрийн дугаартай, Хадат рашаан овогт Лувсандорж-н **БЯМБАЖАРГАЛ**
**Төлөөлөгч:** Орос улс /ОХУ/,Москва, 15-55 хаягт оршин суух RUS12345678 паспортны дугаартай, **АЛЕКСЕЙ ВОРОБЬЕВ** 12345678
**Итгэмжлэлээр олгосон бүрэн эрх:** Төлөөлүүлэгч нь энэхүү итгэмжлэлийн дагуу тогтоол шийдвэр гаргуулах үйлдэл хийх бүрэн эрхийг төлөөлөгчид олгож байна.
**Итгэмжлэлийн хугацаа:** Олгосон өдрөөс эхлэн 15 /арван таван / сарын хугацаанд хүчинтэй. Төлөөлөх эрхийг бусдад шилжүүлэх эрхтэй.

***ИРГЭНИЙ ХУУЛИАС:***

*62.4 Төлөөлөгч итгэмжлэлээр эрх олгосон үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх үүрэгтэй.*
*63.3 Төлөөлөгч нь бүрэн эрхээ шударгаар, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй.*
*67.3 Төлөөлүүлэгч хэдийд ч итгэмжлэлээ хүчингүй болгох, төлөөлөгч итгэмжлэлээс татгалзах эрхтэй.*
*67.4 Төлөөлөгч нь бүрэн эрх дуусгавар болсныг мэдмэгц итгэмжлэлийг төлөөлүүлэгчид буцаан өгөх үүрэгтэй.*
*67.5 Төлөөлүүлэгч итгэмжлэлийг хүчингүй болгосон тухай төлөөлөгч буюу гуравдагч этгээдэд шууд, эсхүл тэдэнд хүргэх боломжтой албан ёсны мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэнэ.*
*67.6 Итгэмжлэл дуусгавар болсныг мэдээгүй буюу мэдэх боломжгүй байхдаа төлөөлөгчөөс бусад этгээдтэй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.*
*70. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс өөртэйгөө, түүнчлэн гуравдагч этгээдийн нэрээр өөрөө төлөөлүүлэгчтэй хэлцэл хийхийг хориглоно.*

Улсын тэмдэгтийн хураамж, визийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай Засгийн газрын 2021 оны 195 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хөлсөнд доллар хураав.
**Энэхүү итгэмжлэлийг олгож буй Л.Бямбажаргал би итгэмжлэлийн агуулга, үр дагаврыг ойлгож, уншиж танилцсан бөгөөд миний хүсэл зоригт бүрэн нийцсэн тул гарын үсэг зурав.**

Л.БЯМБАЖАРГАЛ ______________ ______________

ААЛЕКСЕЙ ВОРОБЬЕВ ______________ ______________ 12345678

Хаах

*Зураг 14.Үүссэн итгэмжлэлийн загвар.*

## *Хавсралт файл харах*

Үйлдсэн итгэмжлэлд хавсаргасан файл харахад миний итгэмжлэл цонхноос харах боломжтой.




*Зураг 15.Итгэмжлэлийн үйлдэлд хавсаргасан файл харах.*

Үйлчилгээний жагсаалтаас хавсралт файл харах итгэмжлэл сонгож жагсаалтын арын 

товч дээр дарна.




*Зураг 16.Хавсралт файл харах цонх.*

## *Үйлдлийн агуулга засах*

Үүсгэсэн итгэмжлэлийн агуулгыг **шинэ** болон **буцаасан** төлөвт засах боломжтой.




*Зураг 17.Үйлдсэн итгэмжлэлийн агуулга засах цонх нээх.*

1. Миний итгэмжлэл жагсаалтаас агуулга засах итгэмжлэл сонгоно.
2. 

товч дээр дарж агуулга засах хуудас нээнэ.
3. Засах мэдээллээ засаад **Хадгалах** товч дарна.




*Зураг 18.Итгэмжлэлийн агуулга засах хуудас нээгдэнэ.*

## *Төлөвийн түүх харах*

Үйлдсэн итгэмжлэлийн жагсаалтаас үйлдэл сонгож **Төлөв** баганадах төлөв дээр дарж ямар хэрэглэгч хянасан , хэзээ ямар төлөвт оруулсан огноо, тайлбарын мэдээлэл харах боломжтой.




*Зураг 19.Төлөвийн түүх харах цонх нээх*




*Зураг 20.Төлөвийн түүх харах цонх.*